



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 14/89

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 14/01 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлого”-ын 4.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын ажиллах шинэчилсэн журмыг 1 дүгээр хавсралтаар, нийслэлд шинээр өмч худалдан авах, эд хөрөнгө бүртгэх, эд хөрөнгийг акталж, данснаас хасах, эд хөрөнгийг балансаас балансад, данснаас дансанд шилжүүлэх баримтын үлгэрчилсэн загварыг 2 дугаар хавсралтаар, данснаас хасах хөрөнгийг үзэж, танилцсан тэмдэглэлийн үлгэрчилсэн загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс” (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Журам батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/578 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.БАЯРАА